



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/331

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн “Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, нийгмийн идэвх оролцоог сайжруулах, мэдлэг, мэдээллээр хангаж, чадавхжуулах зорилгоор дохионы хэлний сургагч багшийг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасугай.

2. Дохионы хэлний сургагч багшийн сургалтын хэрэглэгдэхүүнд шаардагдах 750,000 (долоон зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

